

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
8 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилт, үр дүнд хяналт, үнэлгээ хийж, ажлын хэсэг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газарт хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцаж санал солилцож, хөтөлбөрүүдийн хэрэгжилт үр дүнд хийсэн хяналт, үнэлгээний дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд хүргүүлсэн байна.

Цагаатгалын хуулийн хүрээнд 23 иргэнээс одоогийн байдлаар 3 иргэний 120 сая төгрөгийн шүүхийн шийдвэр гарч санхүүжилт ирээгүй хүлээгдэж байна. Эхний хагас жилийн байдлаар 241 сая төгрөгийг олгох, шүүхийн шийдвэр гарсны дагуу, тухайн иргэний дансанд мөнгийг шилжүүлж олгосон байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны 7-р сарын 30-ны өдрийн 35 дугаар тогтоолоор аймгийн сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан бөгөөд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 27.3 дахь заалтыг үндэслэн МАН, АН, МАХН, ШИНЭ намыг 2020 оны орон нутгийн ээлжит сонгуульд оролцуулах тогтоолыг аймгийн Сонгуулийн Хороо намуудад гардуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Архангай аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн санаачилгаар Архангай аймгийн багш нарын анхдугаар зөвлөгөөн “Боловсролын чанарт ахиц гаргацгаая” уриан доор 2020 оны 8-р сарын 14-16-ны өдрүүдэд Эрдэнэбулган суманд зохион байгууллаа. Зөвлөгөөнд ерөнхий боловсролын, хүүхдийн цэцэрлэгийн нийт 1381 багш оролцож 2020–2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангах, сургуулийн орчинд халдварт өвчнөөс сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах хүрээнд баталсан тушаал, шийдвэр, дүрэм журмыг танилцуулах, орон нутгийн онцлогт тулгуурлан сургалт эхлэх бэлтгэл ажлыг зохион байгуулах, сайжруулсан сургалтын хөтөлбөрийн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэг, үнэлгээний журам, түүнийг хэрэгжүүлэх арга зүй, бюпринт боловсруулах арга зүйн талаар Боловсрол, шинжлэх ухааны яам, БХ, БМДИ, БҮТ-ийн 62 хүний бүрэлдэхүүнтэй баг сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа 172 байгууллагыг хамруулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд дотоод аудит хийхэд аудитын дүнгээр төрийн байгууллагуудын мэдээлэл байршуулалт 2019 оны жилийн эцсийн байдлаар 97%, илгээлт 98.8%-тай гарсан бол 2020 оны эхний хагаст аймгийн дундаж байршуулалт 94%, илгээлт 90%-тай болж шилэн данс нэгдсэн цахим сайтад мэдээлэл байршуулалт, илгээлт ийнхүү улсын дундаж түвшинд хүрсэн байна.

"Хавдрын аюулгүй Архангай" төслийг эхлүүлэх урьдчилсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, төслийг хэрэгжүүлэхэд ямар бэрхшээлүүд тулгарч болох, түүнийг яаж засаж сайжруулах, төслийг хэрэгжүүлэхэд ямар хэмжээний хөрөнгө мөнгө шаардагдах, түүнийг Засгийн газар болон аймаг орон нутгийн түвшинд хэрхэн шийдвэрлэх асуудлыг ярилцсан байна. Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Ж.Мөнхбат, Ж.Чинбүрэн, ХСҮТ-ийн захирал Н.Эрдэнэхүү, бусад холбогдох хүмүүс, аймгийн удирдлагууд, ЭМГ-ын дарга, мэргэжилтнүүд, сумдын ЭМТ-ийн удирдлагууд оролцсон байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Татвар төлөлт

8-р сард улсын төсөвт 101440 мянган төгрөг төвлөрүүлэхээс 101440 мянган төгрөг төвлөрүүлж, орон нутгийн төсөвт 636533.5 мянган төгрөг төвлөрүүлэхээс 636533.5 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 100 хувь биелүүлэн ажиллаж байна.

Хөрөнгө оруулалт

2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 49.076.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 63 төсөл арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 7-р сарын байдлаар 9.331.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4.133.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл арга хэмжээ хэрэгжинэ.

Үүнээс, авто замын сангийн хөрөнгөөр 435.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнээс 18.5 сая төгрөгийн, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.565.3 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 955.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 132.7 сая төгрөгийн 3, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 427.2 сая төгрөгийн зардлаар 13 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа

Худалдан авалтын чиглэлээр 1525.0 сая төгрөгний тендер зарласан ба 320,0 сая төгрөгний төсөвт өртөг бүхий гүйцэтгэгч нарт гэрээ байгуулах эрх олгосон байна.

Орон нутгийн өмчит 28 төсөвт байгууллагад 50.2 сая төг-ийн үндсэн хөрөнгө худалдан авах зөвшөөрлийг олгож, 3 төсөвт байгууллагад 22.8 сая төг-ийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх зөвшөөрлийг олгосон 12 байгууллагад 358 нэр төрлийн 291.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлах зөвшөөрөл олгосон байна.

Санхүүгийн хяналт

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дотоод аудитын дүнг Сангийн яам болон холбогдох газарт хүргүүлсэн.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас тогтоосон 2015-2019 оны нөхөн төлбөрийн барагдуулалтад дотоод аудит хийгдэж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Хууль, хяналт

8-р сард аймгийн хэмжээнд 5 удаагийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол тохиолдсоноос объектын гал түймэр 3, эрэн хайх аврах ажиллагааны дуудлага 1, усны осол 1 удаа тус тус дуудлага ирсэн байна.

УЦУОШТ-с цаг агаарын мэдээ 4 удаа тодруулж, хойд бүсээс 3, хойд бүст 7, ОБЕГ-с 3 мэдээ хүлээн авч, ОБЕГ-т 7 мэдээг дамжуулан удирдлагад танилцуулсан. Мөн ОБЕГ-н “Онцгой” станцаар 163, утсаар 165, мессенжрээр 408, “Зүүм” цахим программаар 82 удаа сүлжээнд орж мэдээ дамжуулж, хүлээн авч ажилласан.

Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт цаг агаарын аюулт үзэгдэл 1 удаа, covid-19 цар тахалаас урьдчилан сэргийлэх анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээг 120 удаа цаг алдалгүй дамжуулж бүртгэл хөтөлж ажилласан байна.

Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан зудын эрсдэлийн үнэлгээ хийх заавраар Архангай аймгийн зудын эрсдэлийн урьдчилсан үнэлгээгээр 19 сумаас эрсдэлийн зэргэлээрээ 13 сум зудын эрсдэлийн түвшин дунд, 6 сум зудын эрсдэлийн түвшин их гарсан байна.

Аймгийн хэмжээнд тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран хяналтын пост гаргаж эргүүл хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж байна.

2020 оны 7-р сард аймгийн хэмжээнд 298 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 74, хулгайлах гэмт хэрэг 141, иргэдийн өмчийн гэмт хэрэг 52, малын хулгайн гэмт хэрэг 78, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 14, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 48, гэмт хэргийн илрүүлэлт 37.3 хувьтай байна.

Нийт 16044 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 15534 иргэнд 513.8 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 1129.3 сая төгрөг, нөхөн төлүүлэлтийн хувь 34.5 хувьтай байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 8-р сард 2705414.7 төгрөгийн мөнгөн дүн бүхий 481 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 39.2, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 31.3 байна.

Мэргэжлийн хяналтын газар ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хичээлийн шинэ жилийн бэлтгэлд урьдчилан сэргийлэх шалгалт хийх, хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдох хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд, “Цэцэрлэг, сургуулийн хичээл эхлүүлэх бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/17 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд аймгийн төвийн 5 сургууль, 11 цэцэрлэгт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, Эрүүл мэндийн газартай хамтран сургалт зохион байгууллаа.

Шүүхийн шинжилгээний алба 8-р сард криминалистикийн шинжилгээ 1, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 74, шүүх эмнэлгийн шинжилгээ 104 шинжилгээ тус тус хийсэн байна.

Иргэний бүртгэл

2020 ий 8-р сард 25-ны өдөр 125-аас 126-аас хэд хэд өөр өөр асуудлыг бичигдсэн байна.

- Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт – 176
- Гэрлэлтийн бүртгэл - 23
- Гэрлэлт цуцалсаны бүртгэл – 1
- Эцэг тогтоосны бүртгэл - 2
- Хүүхэд үрчлэлтийн бүртгэл - 0
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсөний бүртгэл - 7
- Нас баралтын бүртгэл - 44
- Шинээр иргэний үнэмлэх олгосон - 135
- Дахин олгосон – 91
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 296 бүртгэл хийгдсэн байна.
-

Эд хөрөнгийн эрхийн бүртгэл

2020 ий 8-р сард 25-ны өдөр 125-ны өдөр 126-аас хэд хэд өөр өөр асуудлыг бичигдсэн байна.

- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 14
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 11
- Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 0
- Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 0
- Арилжааны гэрээ – 0
- Худалдах худалдан авах гэрээ – 67
- Бэлэглэлийн гэрээ – 10
- Барьцааны эрхийн бүртгэл – 202
- Өв залгамжлал – 9
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 4
- Лавлагаа – 0
- Бусад эрхийн бүртгэл – 7

Хóóëü ðÿíàëòüí ààéáóóëëàáàà àèéò 18 èàâèàáààâ ààðàáí õçðãçëñýí ààéíà. Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 3.804.039 тэмдэгтийн хураамжид 27350 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 15.144.000 төгрөг төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээд

- Шинээр бүртгүүлсэн – 7
- Өөрчлөлт – 3
- Тамганы хяналтын дугаар олгосон –7 бүртгэл хийсэн.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсрол

2020 оны 8-р сарын 16-ны өдөр аймгийн Багш нарын бага хурлыг зохион байгуулж Боловсрол, соёл, урлагийн газрын дарга Ц.Мөнхбат 2019-2020 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын үр дүн, хэрэгжилтийн тайланг хэлэлцүүлж, 2020-2021 оны хичээлийн жилийн зорилго, зорилтыг танилцуулав.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал covid-19 үед хичээл сургуулийг эхлүүлэх гэж байгаатай холбоотой “Цэцэрлэг, сургуулийн хичээл эхлүүлэх бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 6 дугаар сарын А/17 дугаар тушаалын дагуу ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага бэлтгэл ажлыг хангаж байна. Үүнтэй холбоотой мэргэжлийн хяналтын ерөнхий газрын “Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хичээлийн шинэ жилийн бэлтгэл, хоол үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх” 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 01/96 удирдамжийн тайланг нэгтгэн хүргүүлэв.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/145 дугаар тушаалын хэрэгжилт 100%, бага ангийн болон сургуулийн хоол үйлдвэрлэлийн ажилчид урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамрагдсан.

Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд нарын хамтарсан “боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах удирдамж”-ийн хүрээнд Боловсрол, соёл, урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс хамтран бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.

Нөхөн хангалтын сурах бичгийн БШУЯ-наас 100% татаж, ерөнхий боловсролын сургуульд тараах ажил 55 хувьтай зохион байгуулагдаж байна.

Соёл, урлаг

Нийтийн номын сан гэрээр ном олгох үйлчилгээгээр нийтийн уншлагын танхимаар 11 уншигч шинээр бүртгэж, 106 ирэгсдэд 79 ном, 83 тогтмол хэвлэлээр, хүүхдийн уншлагын танхимаар 1 уншигч шинээр бүртгэж, 2 ирэгсдэд 5 ном оор тус тус үйлчилж, Нийтийн уншлагын танхимд монголын түүхийн 45 ном, хичээлийн шинэ жилийн нээлтэд зориулан хүүхдийн уншлагын танхимд хүүхдэд зориулсан 40 шинэ номын үзэсгэлэн гаргаж, нийтийн уншлагын танхимын 1374 нэрийн 1977 ширхэг номыг шивж, бар коджуулсан.

Аймгийн Музей аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3 дахь зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Баруун сэмчингийн шалыг засварлах ажлыг хийж гүйцэтгэн дотоодын аялагч, үзэгчдэд үзвэр, үйлчилгээгээ хэвийн үзүүлж ажиллаж байна.

Мөн Батцэнгэл, Тариат, Өндөр-Улаан, Цахир, Чулуут сумдын түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг бүртгэн баримтжуулсан байна.

Аймгийн Хөгжимт драмын театрын нийт уран бүтээлчид “UBS” телевизтэй хамтран сарлагийн тухай түүхэн кино бүтээхээр 8-р сарын 16-ны өдрөөс эхлэн Чулуут суманд ажиллаж байна.

Эрүүл мэнд

Иргэдийн эрүүл ахуйн хэв маяг, ухамсар соёлыг сайжруулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлж ЭМГ, МХГ, ОБГ, ЦГ-ын нийт 25 алба хаагч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтан, алба хаагч, иргэд нийт 41.410 хүнд шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг хүргэсэн.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх 1, үер усны ослоос урьдчилан сэргийлэх 1, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх 1 төрлийн шторкыг “АВ” телевизээр өдөрт 10 удаагийн давтамжтайгаар нийт 800 минут нэвтрүүлсэн.

Орон нутгийн “АВ”, “Тамир” 2 телевиз, зах худалдааны төвийн 2 узель, Онцгой байдлын газрын 1 чанга яригчаар өдөрт 4 удаа ухуулга сурталчилгаа хийж иргэдэд зарлан мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байна.

Люксембургийн Засгийн газрын дэмжлэг санхүүжилтээр хэрэгжиж байгаа Зүрх төв-МОН 006 төслийн баг 2020 оны 8-р сарын 13-ны өдөр Архангай аймгийн эрүүл мэндийн салбарт ажиллаж Зүрх судасны тусламж үйлчилгээг орон нутагт бэхжүүлэх зорилгоор MN-cardio программ сумын эмнэлгийн модуль хөгжүүлэлтийн бодит байдал цаашдын хөгжил, төслийн хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2020 оны 8-р сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1171 иргэн бүртгэлтэй байгаагаас 615 эмэгтэй. Шинэ ажлын байр 620 үүнээс байнгын ажлын байр 385, улирлын ажлын байр 41, түр ажлын байр 194 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 548, зуучлал 489 байна. Тухайн сарын 20-ны байдлаар 68 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй-6, бага-32, суурь-287, бүрэн дунд-623, техникийн болон мэргэжлийн анхан шатны-24, тусгай мэргэжлийн дунд-17, Дипломын бакалаврын-182 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 17 иргэнийг LMIS программд шивж оруулан тодорхойлолт гарган агч Нийгмийн даатгалын хэлтэсрүү хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын санд 2020 оны 08 дугээр сарын 25-ны байдлаар нийт 11,4 тэр бум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 119 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 14,9 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 35,7 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 4173,7 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын санд 2020 онд 11,4 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,2 тэрбум төгрөгөөр өссөн.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд

- Тэтгэврийн даатгалын санд 65,1 % буюу 7427,6 сая төгрөг
- Тэтгэмжийн даатгалын санд 7,3 % буюу 839,5 сая төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 5,6 % буюу 629,2 сая төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 1,6 % буюу 190,5 сая төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын санд 20,4 % буюу 2309,5 сая төгрөг

2020 оны нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 35,7 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 4,7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

“Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах тухай” Засгийн газрын 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 19 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн А/531 дүгээр захирамж, 05 дугаар албан даалгаврыг гарган, сум, байгууллагын удирдлагуудад хүргүүлэн заавар чиглэл өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Архангай аймгийн хэмжээнд энэ онд 1927.7 мянган толгой эх мал төллөж 1637.3 мянган толгой төл малыг бойжуулсан, мөн зах зээлд 1.2 сая орчим толгой малыг борлуулна гэж тооцвол 6.3 сая толгой мал өвөлжиж хаваржуулах төлөвтэй байна.

Улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 7 сумын 553 малчин өрхийн 193.6 мянган толгой мал, аймаг, орон нутгийн тусгай хэрэгцээний нөөц нутагт 3 сумын 46 малчин өрхийн 30.9 мянган толгой мал, Дорнод, Төв, Булган аймгийн нутагт 2 сумын 7 малчин өрхийн 3695 толгой мал отроор өвөлжинө.

Аймгийн хэмжээнд 6, 7, 8 дугаар саруудад 228 толгой адуу, 301 толгой үхэр, 5500 толгой хонь, 846 толгой ямаа, 7 толгой тэмээ нийт 6882 толгой малыг мал эмнэлгийн гарал үүслийн бичигтэйгээр Улаанбаатар болон томоохон хот суурин газруудад борлуулах ажлыг зохион байгуулсан болно.

Малын генетик нөөцийн тухай хуулийн хүрээнд бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх ажлын хүрээнд 15 сумын 14 мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжид 1777 толгой хуц, 985 толгой ухна нийт 2762 толгой хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлж, бүртгэлжүүлэн малчдад түрээсийн гэрээгээр ашиглуулан хээлтүүлгийн ажлыг мэргэжилтний хяналтан дор зохион байгуулж байна.

Малын чанар үүлдэрлэг байдлыг сайжруулж, цөм сүрэг бүрдүүлэн ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор үржилд зориулан 85.4 мянган толгой хээлтэгч мал, 771 толгой хээлтүүлэгч малыг шинээр бойжуулж, 109 толгой хээлтэгч, 469 толгой хээлтүүлэгч малыг худалдан авч, 6 толгой хээлтэгч, 56 толгой хээлтүүлэгч малыг үржилд худалдан борлуулсан.

Мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Сэлэнгэ, Грефорд, Симентал үүлдрийн гүн хөлдөөсөн үрээр 38 толгой үнээнд зохиомол хээлтүүлэг хийж, мөн Суфолик, Эдельбай үүлдрийн хуцны үрээр 300 толгой хонинд зохиомол хээлтүүлэг хийх ажлыг зохион байгуулж байна.

Монгол үүлдрийн адууны стандартыг тогтоох ажлын хүрээнд Эрдэнэмандал сумын 142 толгой, Хотонт сумын 18 толгой адуунд биеийн үндсэн хэмжилтүүдийг авч генетик нөөцийг тогтооход адууны цус, сүүлнээс дээж авч лабораторид хүргүүлэн зориулалтын бар код бүхий чипээр бүртгэлжүүлэн мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулсан.

Монгол адууны үүлдэрлэг байдал, генетик нөөцийг хамгаалах, бусад цэвэр үүлдрийн адуунаас ялгах, давуу шинж чанаруудыг тогтоох, судалгааны ажил хийхэд ач холбогдолтой юм.

“Бруцеллёз өвчний өвчний вакцинжуулалтыг зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/549 дүгээр захирамжийн дагуу малын бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 8-р сарын 01-ний өдрөөс эхлэсэн бөгөөд 2425680 төл мал хамрагдахаас 485136 хамрагдаж ажлын явц 20 хувьтай байна.

Газар тариалан

Аймгийн хэмжээнд ургацын урьдчилсан балансаар, Улаан буудай 1 га –гаас 10-12 цн, нийт 6795 га талбайгаас 7688 тн, Тэжээл 1 га-гаас 25 цн нийт 3844 га талбайгаас 9612 тн, Тосны таримал 1 га-гаас 8 цн, нийт 901 га талбайгаас 720.8 тн, Төмс 1 га-гаас 100 цн, нийт 267.1 га талбайгаас 2671 тн, Хүнсний ногоо 1 га-гаас 105 цн, нийт 139.5 га талбайгаас 1520.7 тн-ийг тус тус хураан авахаар байна.

Уриншийн хөрс боловсруулалт 12285 га талбайд хийхээс өнөөдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна. Ургац хураах ажиллах комбайн 18, ангилан хадах жатка 16, будаа цэвэрлэгч 5, сортлогч 1, будаа ачигч 7, төмс ухагч 20, нийт 67 техник, тоног төхөөрөмж бэлэн байна.

2020 оны 6-р сараас эхлэн хур бороо орж таримлын ургац хэвийн болж ирсэн ч мөндөр, үер их хэмжээгээр орж Өлзийт, Эрдэнэбулган сумдын 844 га талбайн Улаан буудай тэжээлд шилжих төлөвтэй байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин, аялал жуулчлал

Аялал жуулчлалын шинэ эвент арга хэмжээ бий болгох зорилгоор “Цагаан лавай трайвл” ХХК, Циркчин М.Мягмарсайхантай хамтран Skywalk Чулуутын хавцал дээгүүр 50 метрийн өндөр 130 метр олсон дээгүүр алхах үзүүлбэрийг 8-р сарын 08-ны өдөр зохион байгуулж, энэхүү арга хэмжээг 4000 гаруй хүн үзэж сонирхлоо.

“Хоггүй аялал гоё” аяныг үргэлжлүүлэн зохион байгуулж байгаа бөгөөд 8-р сард 6000 гаруй жуулчин энэхүү аянд нэгдээд байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 8 дугаар сарын 04-ний өдөр баталсан удирдамжийн дагуу байгаль орчны болон тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх “Хяналт” арга хэмжээг зохион байгуулж, хяналт шалгалтын ажил гүйцэтгэж байна.

Ойг хамгаалах, зүй зохистой ашиглуулах зорилгоор самрын болц гүйцэхээс нь өмнө түүж бэлтгэхээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хушин ой бүхий сумдын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн гишүүдийн 60 гаруй төлөөллийг хамруулсан уулзалтыг зохион байгууллаа.

Хүнс, үйлдвэрлэл үйлчилгээ

Архангай аймгийн эдийн засгийн гол салбар нь хөдөө аж ахуйн салбар бөгөөд аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 55.1 хувийг эзэлж байна. Аймгийн хэмжээнд хүнсний чиглэлийн 68 үйлдвэр, цех 239 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж, үйлдвэрлэлийн хүчин чадлынхаа 83 хувийг ашиглаж, 9.04 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 12.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, дотоодын үйлдвэрлэлээр мах 34.4 мян.тн бэлтгэж 100%, сүү 56 сая.литр бэлтгэж 100%, гурил 0.36 мян.тн бэлтгэж 12.5%, гурилан бүтээгдэхүүн 2.45 мян.тн бэлтгэж 39%, төмс 2.5 мян.тн бэлтгэж 63.8%, хүнсний ногоо 0.8 мян.тн бэлтгэж 14%, жимс, жимсгэнэ 0.013 мян.тн бэлтгэж 0.25%-иар аймгийн хүн амын хүнсний хэрэгцээг хангаж байна.

Аймгийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд санд 32 аж ахуйн нэгж, хоршооны 3.972.661.800 төгрөгийн санхүүжилт хүссэн төслийг битүүмжлэн хүлээн авсан.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулах аймгийн Дэд хорооны 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу 8 аж ахуйн нэгж, хоршооны 845.0 сая төгрөгийн төслийн жагсаалтыг аймгийн Засаг даргын 2020 оны 07 сарын 31-ний өдрийн А/514 тоот захирамжаар батлан Хүнс, хөдөө аж ахуйн ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хүргүүлээд байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----